



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/902

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын 8 байгууллагын халаалтын хэвийн нөхцлийг хангахаар шугам сүлжээнд хяналт, засвар үйлчилгээ, угаалга хийхэд ажилласан “Ховд дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компаний 15 ажилчдын гүйцэтгэсэн ажлын хөлсөнд 7500,0 мянган төгрөгийг хавсралтаар баталж олгосугай.


2.Халаалтын шугам сүлжээнд засвар, үйлчилгээ, угаалга хийсэн ажлын хөлсөнд олгох 7500,0 мянган төгрөг /долоон сая таван зуун мянган/-ийг аймгийн хөрөнгө оруулалтын захиалагчийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар  
сарын 23-ны өдрийн А/902 дугаар  
захирамжийн хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН 8 БАЙГУУЛЛАГЫН ХАЛААЛТЫН ШУГАМ  
СҮЛЖЭЭНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ,  
УГААЛГЫН АЖЛЫН ХӨЛСНИЙ ЗАРДАЛ

ДД	Үзүүлэлт	Ажилласан		Нэг хүний ажлын хөлс /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
		Хугацаа	хүний тоо		
1	Байгууллагын халаалтын шугам сүлжээнд хийсэн хяналт, засвар үйлчилгээ, угаалгын ажлын хөлс /ГХБХБГ, 14 дүгээр цэцэрлэг, БОЭТ, Жаргалант өрхийн эмнэлэг, Усан спорт сургалтын төв, ДДТ-16, 12 дугаар цэцэрлэг, БОЭТ төрөх эмнэлэг/	2019.08.15 - 2019.09.15	15	500000.00	7500.0
	Дүн				7500.0

-oOo-